



МОНГОЛ
УЛСЫН
Дотоод
Хэрэгний
Төрийн
Тасаа

ЦАХИМ ХЭРЭГСЭЛ АШИГЛАН ҮЙЛДСЭН ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТҮҮНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ

ANALYSIS OF THE CURRENT STATE OF CRIME PREVENTION WORKS BY POLICE ORGANIZATIONS

О.Одонбаатар

Дотоод хэргийн их сургуулийн докторант

O. Odonbaatar

Doctoral student of the University of Internal Affairs, Mongolia

*Хариуцлагатай зохиогч: odonbaatar_o@yahoo.com

Хураангуй: Сүүлийн жилүүдэд Монгол Улсад цахим орчныг ашиглаж үйлдсэн залилах гэмт хэрэг эрчимтэй өсч, иргэд хохирогч болох тохиолдол улам бүр нэмэгдсээр байна. Мэдээллийн технологи хурдацтай хөгжиж, даяаршлын нөлөө гүнзгийрсэн өнөө үед цахим орчин нь хүн төрөлхтний харилцаа, мэдээлэл солилцооны гол платформ болсон тул иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг хангах, түүнтэй холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлага нэн тулгамдсан асуудал болж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь нийгмийн аюулгүй байдлыг хангах зорилготой олон талт, цогц процесс бөгөөд гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлж буй шалтгаан, нөхцөлийг тодорхойлох, тэдгээрийг арилгахын зэрэгцээ иргэдийн оролцоонд тулгуурласан үр нөлөөтэй арга хэмжээг хэрэгжүүлэхийг шаарддаг. Судалгааны үр дүнгээс харахад гэмт хэрэг үйлдэгдэх боломжит эрсдэлийг бууруулах, мөн эрсдэлийн суурь хүчин зүйлсийг тодорхойлон түүнд суурилсан урьдчилан сэргийлэх стратеги боловсруулах нь хамгийн үр ашигтай арга зам гэдгийг харуулсаар байна.

Гадаад улс орнуудын туршлагаас үзвэл гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйлсэд иргэдийн идэвхтэй оролцоо, сайн дурын байгууллагуудын хамтын ажиллагаа чухал байр суурь эзэлдэг. Харин Монгол Улсад энэ чиглэлийн эрх зүйн орчныг үе шаттай шинэчилж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд цахим технологи, хиймэл оюун ухаан, цахим хэрэгслүүдийг ашиглан урьдчилан сэргийлэх ажлын үр өгөөжийг нэмэгдүүлэх шинэ чиг хандлага бүрэлдэж байна.

Иймд энэхүү судалгааны зорилго нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого, стратегийг шинэлэг хэлбэрээр боловсруулж хэрэгжүүлэх шаардлага, чиглэлийг тодорхойлох, мөн мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл өсөж буй өнөөгийн нөхцөлд илүү үр нөлөөтэй, шинжлэх ухаанд суурилсан арга зүйг санал болгоход оршино.

Abstract: In recent years, citizens of Mongolia have increasingly fallen victim to fraud crimes committed through electronic means. The digital environment has become the main bridge for global communication and information exchange, underlining the urgent need to enhance the legal framework for ensuring information security for individuals, enterprises, and organizations to prevent the risks of information threats as shown by today's societal development.

Crime prevention activities focus on securing social safety, reducing the conditions and causes of criminal acts, and implementing sustainable measures based on citizen participation, representing a multifaceted process. Studies have identified the main objective as reducing the potential risks of crimes, analyzing their causes and conditions, and developing prevention strategies based on these findings.



Examining the experiences of other countries reveals that active citizen involvement and the support of volunteer organizations play a crucial role in enhancing the effectiveness of crime prevention efforts. In Mongolia, there is an emerging trend to improve the efficiency of prevention work by gradually updating the legal framework for crime prevention and integrating digital technology, artificial intelligence, and electronic tools into law enforcement activities.

Therefore, this study aims to identify the requirements and directions for implementing crime prevention policies and strategies in an innovative manner.

Түлхүүр үгс: Гэмт хэрэг, урьдчилан сэргийлэх, арга хэмжээ, хууль, хөтөлбөр, цагдаагийн байгууллага

Keywords: Crime, Prevention, Measures, Laws, Programs, Police

Удиртгал

Хүн төрөлхтөн нийгмийн хөгжлийн бүхий л үе шатанд гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх асуудлыг онцгойлон авч үзсээр ирсэн. Эрт үеэс гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял шийтгэл оногдуулах замаар нийгмийн дэг журмыг сахиулахыг зорьж байсан боловч энэхүү арга нь гэмт явдлын гаралтыг бүрэн зогсоох үр нөлөөтэй бус болох нь тодорхой болсон. Иймээс гэмт хэрэгтэнг зөвхөн цээрлүүлэх бус, түүнээс урьдчилан сэргийлэх, зан төлөвийг өөрчлөх, нийгмийн зөв хандлагад чиглүүлэх олон талт үзэл санаа бий болж, улмаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх онолын үндэс бүрэлдэн тогтжээ.

XXI зуунд шинжлэх ухаан, технологийн хурдацтай хөгжил, ялангуяа цахим хэрэглээ, цахим орчны нөлөө нь хүн төрөлхтний өдөр тутмын амьдралын салшгүй хэсэг болсон. Цахим хэрэглээ нь мэдээлэл солилцох, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, цаг хугацааг хэмнэх зэрэг эерэг үр нөлөөтэй хэдий ч нөгөө талаас цахим орчныг ашигласан гэмт хэрэг дэлхий даяар хурдацтай нэмэгдэж байна.

Судалгаагаар дэлхийн хүн амын 56 орчим хувь нь интернэт ашигладаг бөгөөд Монгол Улсын хувьд хүн амын дийлэнхийг идэр насны залуус эзэлдэг нь Ази тивд интернэт хэрэглээний түвшнээр дээгүүр байранд ордог болохыг харуулж байна. Тэдгээрийн 96 хувь нь “Фэйсбүүк” платформыг идэвхтэй ашигладаг гэсэн судалгаа нь цахим орчны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шинэ чиглэл, арга хэрэгслийг боловсруулах шаардлага улам бүр нэмэгдэж буйг илтгэнэ.

Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудал нь хүн төрөлхтний соёл иргэншлийн түүхэн явцад анхаарал татаж, шийдвэрлэх шаардлагатай төдийгүй чухал асуудлын нэг хэвээр үлдсэн. Хүн төрөлхтөн үүссэн цагаасаа гэмт явдлын эх үүсвэр бүхий аюултай байнга нүүр тулан, хатуу чанд ял шийтгэлийн хүчээр хориглон зогсоохыг оролдож ирсэн боловч, энэ нь боломжгүйг ухаарсан цагаас эхлэн нийгмийн сөрөг үзэгдлийн хамгийн тод илрэл болсон гэмт явдлаас урьдчилан сэргийлэх тухай ойлголтыг бий болгожээ (Г.Даштүдэв, 2007, хууд. 45)

Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ бол "тэмцэх" ажиллагааны үндсэн чиглэл, баримтлах гол шугам болдог. Гэмт явдалтай тэмцэх гэж гэмт явдлын гаралтыг багасгах, нийгмийн хор аюулыг бууруулах, шалтгаан нөхцөлийг арилгах буюу саармагжуулах зэрэг нарийн зохион байгуулалт бүхий, системтэй үйл ажиллагаануудын цогцыг ойлгоно. Харин гэмт явдлаас урьдчилан сэргийлэх гэж гэмт явдлын гаралтыг хорогдуулах, түүнийг төрүүлдэг шалтгаан, нөхцөлийг арилгахад чиглэгдсэн төр, олон нийтийн байгууллага, иргэдээс зохион явуулж байгаа үйл ажиллагааны системийг ойлгож болно (Г.Думбарай, 1987, хууд. 145).

Дээрх дүгнэлтүүдийг нэгтгэн үзвэл гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал нь нийгмийн сөрөг үзэгдлийн гарал, шалтгааныг тодорхойлж, түүнээс урьдчилан сэргийлэх арга замыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхойлох чухал асуудал юм. Гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаа нь гэмт явдлын гаралтыг бууруулах, хор уршгийг саармагжуулах,



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠰᠤᠶ᠋ᠠᠨ ᠰᠠᠬᠢᠭᠣᠯᠠᠬᠤᠢ

шалтгаан нөхцөлийг арилгах зэрэг нарийн зохион байгуулалттай системийг хамардаг бол гэмт явдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь төр, олон нийтийн байгууллага болон иргэдийн оролцоонд тулгуурлан гэмт хэрэг гарах нөхцөл, шалтгааныг бууруулах, нийгмийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн урт хугацааны бодлого, стратегийн цогц ойлголт юм.

Цахим хэрэгсэл ашиглан үйлдэгдэж байгаа залилах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалт

Сүүлийн жилүүдэд үйлдлийн арга, хүрээ хязгаар нь улам бүр өргөжиж буй гэмт хэргүүдийн нэг нь цахим орчинд үйлдэгдэж байгаа залилах гэмт хэрэг бөгөөд нийгэм, эдийн засаг, эрх зүй, ёс суртахууны түвшнээс шууд хамаардаг. Энэ гэмт хэргийн улмаас зөвхөн хувь хүн бус аж ахуйн нэгж, төр, хуулийн этгээдээс гадна олон улсын байгууллагууд эд хөрөнгийн хохирол амссаар байна.

Түүнчлэн залилах гэмт хэргийг орчин үеийн шинжлэх ухааны ололт, дэвшилтэд тулгуурлан үйлдэх болсон нь анхаарал татах боллоо. Богино хугацаанд их хэмжээний хохирол учруулах, хохирогчдын тоо ч улам өсөх хандлагатай байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх төрийн эрүүгийн бодлогыг олон улсын жишигт нийцүүлэн тодорхойлох, шинэчлэх, зарим төрлийн арга хэлбэрийг хуульчлах, өргөжүүлэх шаардлага үүсээд байна.

Залилах гэмт хэрэг нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн бүлэгт багтах бөгөөд энэ төрлийн гэмт хэргийн нийтлэг шинж чанаруудыг агуулж байгаа төдийгүй, өөрийн онцлог шинж чанаруудтай, эдгээр нь эрүүгийн эрх зүйн үүднээс тайлбарлагддаг.

Залилах гэмт хэрэг нь бусдын эд хөрөнгө, эрх ашигт халдах зорилгоор хууран мэхлэх, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим төхөөрөмж, хэрэгслийг ашиглан эсвэл зохиомол байдлыг зориудаар үүсгэж, бодит мэдээллийг нуух замаар хүнийг төөрөгдөлд оруулж, нэр хүнд, өмнөх харилцааны итгэлцлийг

урвуулан ашиглаж, эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг хууль бусаар шилжүүлэхийг хэлэх бөгөөд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дахь зүйлд тодорхойлж, хариуцлага тооцохоор заасан, нийгэмд сөрөг нөлөөтэй үйлдэл юм.

Залилах гэмт хэргийг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлд хуульчлан тодорхойлохдоо:

1. Хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан бол 450,000-14,000,000 хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 240-720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл 6 сараас 3 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 6 сараас 3 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийг:

2.1. Албан тушаалын байдлаа ашиглаж;

2.2. Бусдад ноцтой, эсхүл их хэмжээний хохирол учруулж үйлдсэн бол 10,000,000-40,000,000 хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 2 жилээс 8 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3. Энэ гэмт хэргийг:

3.1. Байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон;

3.2. Олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын аргаар үйлдсэн;

3.3. Зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол 5 жилээс 12 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж үндсэн, хүндрүүлэх болон онц хүндрүүлэх шинжтэйгээр хуульчилсан ба гэмт хэргийн ангиллын хувьд үндсэн шинж нь хөнгөн, хүндрүүлэх, онц хүндрүүлэх шинж нь хүнд гэмт хэрэгт хамаардаг (хууль, 2015).

Эрүүгийн хуульд заасан залилах гэмт хэргийн дундаас сүүлийн жилүүдэд эрчимтэй үйлдэгдэж буй хэлбэр бол цахим

хэрэгсэл ашиглан үйлдсэн залилах гэмт хэрэг юм.

Дэлхий дахинд өрнөж буй хурдацтай хөгжилтэй зэрэгцэн манай улсад цахим хэрэглээ нийгмийн бүх үе шатанд эрчимтэй ашиглагдаж байна.

Цахим хэрэгсэл ашиглан үйлдэгддэг залилах гэмт хэргийн онцлог нь цаг хугацаа, орон зай, нутаг дэвсгэрээс үл хамааран үйлдэгдэж болох явдал юм. Өөрөөр хэлбэл, хэн нэгэн ямар улс оронд оршин суудаг үл хамааран цахим хэрэгсэл, нийгмийн сүлжээнд идэвхтэй оролцож байгаа бол энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болох эрсдэл өндөр байдаг.

Иймд, энэ төрлийн гэмт хэргийг шалгахад цаг хугацаа, санхүүгийн хөрөнгө, мэргэшсэн мэргэжилтэн ихээр шаардлагатай болдог. Манай улсын нөхцөл байдалд хуурамч цахим хаяг ашиглан интернэт худалдаа нэрийн дор залилах, зээлийн аппликейшны болон таатай нөхцөлөөр зээл олгох, цахим маркетинг болон жижиглэн худалдаа, байр худалдах, түрээслэх болон цахим платформд онлайн цагийн ажил хийлгэх, сугалаа зэрэг хэлбэрээр залилах гэмт хэрэг түгээмэл гарч байна.

Цар тахлын үед онлайн худалдаа эрчимтэй хөгжсөнтэй холбоотойгоор энэхүү үйл явцыг гэмт хэрэг үйлдэхдээ ашиглаж буй тохиолдол ихээхэн бүртгэгдэж, цаашид өсөх хандлагатай байна. Цахим хэрэгсэл ашиглан залилах гэмт хэрэг нь өмнө ихэвчлэн Facebook сүлжээнд илэрдэг байсан бол одоо Инстаграм, Телеграм, Твиттер зэрэг олон нийгмийн сүлжээнд ч өргөн тархжээ. Хохирогчид нь гэнэт мөнгө хөрөнгө, цаг хугацаа, сэтгэл зүйгээрээ хохирсон байдлаар илэрч байна. Хохирлыг мөнгөн дүнгээр хэмжихээс гадна, энэ үйлдлийн цаана нийгмийн сэтгэл зүйн болон үнэт зүйлсийн хор уршиг үүсэн гарч байгааг дурдах нь зөв.

Манайд улсад тархаад байгаа цахим хэрэгсэл ашиглан үйлдсэн залилах гэмт хэргийг товч задалж тайлбарлавал:

1. Сайтын залилан. Бизнесийн түншүүдийнх нь хаяг, сайтыг хуурамчаар

хийж захиалгын болон гэрээний төлбөр тооцоог нь шилжүүлж авдаг хэрэг. Энэ хэрэгт олны танил хүмүүсийн пэйж хуудас, байгууллагын нэр ашиглах тохиолдол их байна.

2. Онлайн захиалгын луйвар нь 2020 оны Ковидын хөл хорионы үеэс хурдацтай тархаж, илэрхий ихэссэн. 2022 оны эхний улиралд нийт 1,233 иргэн цахим захиалга хийж, залилах гэмт хэргийн хохирогч болж цагдаагийн байгууллагад гомдол гаргасан байна. Хохирогч болох эсэх нь иргэний өөрийн хариуцлагаас шууд хамаардаг бөгөөд санхүү болон мөнгөний гүйлгээ хийхдээ биечлэн урьдчилан нягтлах, шалгаж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор зөвөөр шийдвэр гаргах шаардлагатай байдаг.

Дэлхий нийтийн өмнө тулгараад байгаа 4 томоохон хэргийн нэг нь цахим хэрэгсэл ашиглан үйлдсэн залилах гэмт хэрэг байдаг бөгөөд технологи мэдэхгүй, сошиал орчныг сэтгэлийн хөөрлөөр нягтлахгүй ашигладаг байдлаас дотоодын болон гадаадын залилагч этгээдүүдэд залилуулж хохирсоор байна. Залилах гэмт хэрэг өөрөө хүний эд хөрөнгөнөөс гадна маш их хор хохирол, нийгмийн аюулыг дагуулдаг муу үр дагавартай.

Сүүлийн жилүүдэд цахим хэрэглээ эрс нэмэгдэж, иргэд гэрээсээ гаралгүйгээр хүссэн бараа, бүтээгдэхүүнээ онлайнаар захиалж, хүргэлтээр авах үйлчилгээ хурдацтай хөгжиж, энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлэгч олон байгууллага үүсэн байгуулагджээ. Энэ төрлийн худалдаа, үйлчилгээ нь иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэж буй давуу талтай ч, үүнтэй зэрэгцэн холбогдох эрсдэлүүд ч үүсэх болсон байна.

Олон нийтийн сүлжээнд үйл ажиллагаагаа явуулж найдвартай үйлчилгээ үзүүлдэг онлайн худалдааны дэлгүүр, пэйж хуудсыг дуурайж маш төстэй байдлаар шинэ хаяг үүсгэх, тухайн цахим хаягт байрлуулсан зар бусад нийтлэлийг өөрийн мэт авч ашиглах, гадаад улсаас онлайнаар лайв бичлэг хийж бараа бүтээгдэхүүний захиалга авч иргэдээс төлбөрийг авах замаар иргэдийг





МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ САХИУЛАХ
ОРГОН

төөрөгдөлд оруулан залилах гэмт хэрэг үйлдэгдэж байна.

Онлайн дэлгүүрээр үйлчлүүлж байгаа иргэдийн хувьд албан ёсны сайт, хуудас мөн эсэх тухайн цахим хаяг нь үйл ажиллагаагаа хэзээнээс хойш үнэхээр явуулж байгаа зэргийг сайтар хянаж байж захиалга хийх шаардлага тулгарч байна.

Түүнчлэн мөрийтгэй тоглоом, азийн сугалаа зохион байгуулах нэрийдлээр орлого олох боломжийг эрж, иргэдийг залилах, цахим орчинд оюуны эрхийг зөрчиж, зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг зөрчсөн гэмт хэргүүд ч тодорхой хэмжээнд бүртгэгдэж, шинэ төрлийн гэмт хэрэг жил ирэх тусам өсч байна.

Цахим хэрэгсэл ашиглан үйлдэгдэж буй залилах гэмт хэрэг нь дараах шалтгаан, нөхцөлтэй байна:

1. Иргэд нийгмийн сүлжээнд нэвтрэх нэр, нууц үг үүсгэхдээ өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, утасны дугаар зэрэг энгийн бөгөөд тааварлахад хялбар мэдээллийг ашигладаг;

2. Өгөөш бүхий мэдээллийг уншихаар сонирхон дарж нэвтрэх нэр, нууц үгээ алддаг, “зээл олгоно”, “илгээмж явуулна” “сугалаанд хожсон”, гэх байдлаар иргэдийг төөрөгдөлд оруулж, амар хялбар аргаар мөнгө олох гэсэн санаа, сэдлийг төрүүлж улмаар уг зүйлсийн татвар хураамж, тээврийн зардлыг шилжүүлнэ үү гэх зэргээр цахим мэдээллийн хэрэгслээр түгээгдэж буй мэдээлэл үнэн зөв эсэх талаар нягтлан судалж үздэггүй;

3. Цахим орчны хэрэглээнд хүүхдэд тавих хяналт сул байгаа нь хүүхэд янз

бүрийн сөрөг мэдээллийг хялбар авах нөхцөл бүрдсэн;

4. Цахим мэдээллийн хэрэгслүүдийг зөв, зохистой ашиглах мэдлэгийн дутагдал, хувь хүний амар хялбар орлого олохыг эрмэлзсэн сэтгэл зүйн онцлог, анхаарал сул хандлага нөлөөлж байна гэж үзэхээр байна.

Үүнээс гадна Европын зөвлөл мэргэжлийн экспертүүдийн хороо байгуулж, хууль зүйн асуудлыг хэлэлцсэний үр дүнд Зөвлөмж №R (8 9) 9 гаргасан байна. Энэхүү зөвлөмжид компьютертой холбоотой хууль зөрчсөн үйлдлүүдийн жагсаалтыг гаргажээ (Хороо Е. з., 1989.09.13).

Мөн 1990 онд энэхүү асуудлыг Монреал хотод болсон Харьцуулсан эрх зүйн Олон улсын Академийн 13 дугаар Конгресс болон Гавана хотод болсон НҮБ-ын 8 дугаар Эрүүгийн эрх зүйн Конгресс (Sieber, 1991), 1992 онд Холбооны бүгд найрамдах Герман улсын Вурцбург хотод Олон улсын конференци (Sieber, Information Technology Crime – National Legislation's and International Initiatives, 1994) дээр хэлэлцсэн байна.

Цахим хэрэгсэл ашиглан үйлдэгдсэн гэмт хэргийн статистик мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ

Манай улсын хэмжээнд залилах гэмт хэрэг сард 1748, хоногт 58 буюу, 1 цагт 2-3 гарч, хохирогчдын тоо, хохирлын хэмжээ нэмэгдэж байна.

Цагдаагийн байгууллагад 2020-2023 он, 2024 оны эхний 05 сарын байдлаар нийт 137.349 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 40839 буюу 29.7 хувийг Залилах төрлийн гэмт хэрэг эзэлж байна.




График 1. Залилах гэмт хэргийн нийт хэрэгтэй харьцуулсан байдал



Дээрх хугацаанд залилах төрлийн гэмт хэрэг нийт 40839 бүртгэгдсэн ба жилд дунджаар 8913, сард 1748, хоногт 58 гэмт хэрэг бүртгэгдсэн нь жилийн дунджаар 10.4%-ийн өсөлттэй байна.

Нийт залилах гэмт хэргийн 34022 буюу 83.3 хувь нь нийслэлд, 6786 буюу 16.6 хувь нь орон нутаг, 31 буюу 0.1 хувь нь бусад газарт бүртгэгджээ. Залилах төрлийн гэмт хэрэг нийслэлд ихээр үйлдэгдэж

байгаа нь хүн амын нягтаршил, бэлэн мөнгө, бараа бүтээгдэхүүний эргэлт ихтэй, хот суурин, зах худалдааны төвүүд олноор төвлөрсөн газарт үйлдэгдэж байна.

Үйлдэгдсэн хугацаагаар нь авч үзвэл залилах гэмт хэрэг 2023 онд 12985 бүртгэгдсэн байгаа хамгийн их буюу нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 36.5%, 2020 онд хамгийн бага буюу нийт гэмт хэргийн 18.5%-ийг эзэлж байна.

Нутаг дэвсгэрээр	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024.05 он	нийт
Баян-Өлгий	31	22	55	105	37	250
Говь-Алтай	20	49	47	53	42	211
Завхан	15	39	54	32	13	153
Увс	6	19	28	60	8	121
Ховд	50	67	134	114	73	438
Архангай	13	35	58	32	28	166
Баянхонгор	28	38	83	46	94	289
Булган	15	23	60	36	17	151
Орхон	84	95	185	193	113	670
Өвөрхангай	26	53	108	56	34	277
Хөвсгөл	26	273	323	87	38	747
Говьсүмбэр	19	15	24	16	21	95
Дархан-Уул	78	103	170	153	120	624
Дорноговь	37	99	163	168	114	581
Дундговь	13	31	28	32	12	116
Өмнөговь	26	87	103	171	75	462
Сэлэнгэ	40	104	112	110	42	408
Төв	30	22	71	60	48	231
Дорнод	34	46	70	55	45	250
Сүхбаатар	29	38	74	55	37	233
Хэнтий	26	48	76	121	42	313
Орон нутаг	646	1306	2026	1755	1053	6786
Баянгол	871	1238	2212	2251	865	7437
Баянзүрх	1060	1286	2613	2919	938	8816
Сүхбаатар	548	836	1610	1821	577	5392
Сонгинохайрхан	322	526	721	828	450	2847
Хан-Уул	341	604	1174	2059	752	4930
Чингэлтэй	435	700	1382	1217	494	4228
Багануур	15	23	29	34	21	122
Багахангай	1	1	0	4	0	6
Налайх	28	26	69	87	34	244
Нийслэл	3621	5240	9810	11220	4131	34022
Бусад	3	12	3	10	3	31
Нийт	4270	6558	11839	12985	5187	40839

Хүснэгт 1. Залилах гэмт хэргийг үйлдэгдсэн газраар нь харьцуулан харуулбал,
/2020-2023 он, 2024 оны эхний 5 сар/

Нийслэлд бүртгэгдсэн залилах гэмт хэргийн 8816 буюу 21.6% нь Баянзүрх

дүүрэг, 7437 буюу 18.2% нь Баянгол дүүрэг, 5392 буюу 13.2% нь Сүхбаатар



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ САХИУЛАХУЙ

дүүрэг, 4930 буюу 12.1% нь Хан-уул дүүрэг, 4228 буюу 10.4% нь Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн байна.

Орон нутгийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 747 буюу 11% нь Хөвсгөл, 670 буюу 9.9% нь Орхон, 624 буюу 9.2% нь Дархан-Уул, 581 буюу 8.6% нь Дорноговь, 462 буюу 6.8% нь Өмнөговь, 438 буюу 6.5% нь Ховд аймагт тус тус бүртгэгдсэн нь бусад аймгуудаас өндөр байна.

Залилах гэмт хэргийн 75.1 хувийг хуурч мэхлэх арга, 12.2 хувийг итгэл эвдэх, 2.2 хувийг зээл нэрийн дор залилан үйлдэх, 1.2 хувийг гэрээ байгуулж ашиглах, 2.0 хувийг хуурамч баримт бичиг үйлдэж, 7.3

хувийг бусад арга, хэлбэрүүдийг ашиглан үйлдсэн байна. Энэ төрлийн гэмт хэрэг нь бусдыг төөрөгдөлд оруулж, өмнө нь олж авсан итгэлийг урвуулан ашиглан эд хөрөнгө эсвэл эрхийг хууль бусаар шилжүүлэх, биелэх боломжгүй зүйлсийг боломжтой мэт итгүүлэх, байхгүй зүйлийг үнэн мэтээр төөрөгдөлд оруулах зэрэг санаатай үйлдлүүдээр үйлддэг онцлогтой байна.

Улсын хэмжээнд сүүлийн 5 жилд /2020-2013 он, 2024 оны эхний 5 сард/ цагдаагийн байгууллагад нийт 40839 залилах төрлийн гэмт хэрэг бүртгэгдсэнээс 23921 буюу 58.6 хувь цахим хэрэгсэл ашиглаж үйлдэгдсэн байна.




График 2. Цахим хэрэгсэл ашиглан үйлдсэн залилах гэмт хэрэг /2020-2023 он 2024 оны эхний 05 сар/

Цахим хэрэгсэл ашиглан үйлдсэн залилах гэмт хэрэг 2020 онд 1281, 2021 онд 3865, 2022 онд 7708, 2023 онд 7906 гэмт хэрэг болж тус тус өссөн бөгөөд 2024 оны эхний 5 сард 3161 бүртгэгдсэн байна.

Цахим худалдаа тасралтгүй хөгжихийн хэрээр онлайн шоп, цахим худалдан авалт, хэрэглэгчдийн хүсэл сонирхолд нийцсэн, хурдан шуурхай цаг хэмнэх зэрэг олон давуу талыг харуулж буй нь өнөөгийн нийгэмд хэрэглэгчдийн дунд хэдийн хүлээн зөвшөөрөгдсөн талаар дээр мөн дурдсан. Манай улсад цахимаар бараа бүтээгдэхүүн худалдаж авах үйлчилгээ үзүүлэгч худалдааны сувгийн төрлийг авч үзвэл, иргэдийн 43 хувь нь Facebook сүлжээг ашиглан, 35 хувь нь онлайн худалдааны вэб сайтаар, 6 хувь нь Инстаграм платформыг сонгож байгаа бол, бусад 16 хувь нь эдгээр сонголтуудыг аль алийг ашиглан худалдан авалт хийдэг

байна. Энэ нь иргэдийн ихэнх хэсэг цахим орчинд нэвтрэн, нийгмийн сүлжээгээр бараа, бүтээгдэхүүн худалдан авах соёл үүсч байгааг харуулж байна.

Жил тутамд өсөн нэмэгдэж буй техник технологийн шинэчлэл, компьютер, ухаалаг утасны хэрэглээнээс шалтгаалж, цахим хэрэгсэл ашиглан үйлдсэн залилах гэмт хэрэг, халдлага улам нэмэгдэх болсон. Монгол Улсын хэмжээнд 2020 оноос 2024 оны эхний 5 сарын байдлаар цахим орчинд үйлдэгдсэн 28156 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд жилд дунджаар 78.2 хувиар өсөх бүртгэгдсэн байна.

Цахим хэрэгсэл, цахим сүлжээ ашиглан үйлдэж байгаа гэмт хэргүүд ихэвчлэн зохион байгуулалтад шилжсэн, дэлхийн аль ч улс орноос интернэтийн сүлжээ ашиглан үйлдэгдэж байна. Манай улсын иргэд facebook, instagram, gmail, yahoo зэрэг хилийн чанадад сервертэй веб

сайтуудыг хэрэглээндээ ашигладаг. Энэ төрлийн гэмт хэргийн дийлэнх хувь нь хуурамч хаягаас хандаж, иргэдтэй харилцаа тогтоон үйлдэгддэгээс гадна 30 орчим хувь нь “Facebook” платформыг ашигласан, үүнээс 95.6 хувийг залилах гэмт хэрэг эзэлж байна.

Үүнээс үзэхэд, иргэд цахим орчинд аюулгүй байдалдаа анхаарч, хамгаалалтын арга ажиллагааг сайн ойлгож, хэрэгжүүлэх

нь чухал бөгөөд мөн энэ чиглэлийн хууль эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгаа нь энэ төрлийн гэмт хэргийн гаралтыг нэмэгдүүлэх нэг шалтгаан болж байна.

Энэ төрлийн гэмт хэрэгт сүүлийн 5 жилийн байдлаар 23921 хүн хохирсон, тэдний 14439 буюу 60.4 хувь нь эмэгтэй, 9482 буюу 39.6 хувь нь эрэгтэй, 131 буюу 0.5 хувь нь 14-17 насны хүүхэд байна.




График 3. Залилах гэмт хэргийн хохирогчийг хүйсээр нь ангилбал /2020-2024 он/

Хохирсон иргэдийн 0.5 хувь нь 0-17 насны, 15.0 хувь нь 18-24 насны, 14.4 хувь нь 25-29 насны, 18.3 хувь нь 30-34 насны, 16.3 хувь нь 35-39 насны, 12.2 хувь

нь 40-44 насных, 9.2 хувь нь 45-49 насны, 10.4 хувь нь 50-59 насны, 3.5 хувь нь 60 аас дээш насныхан байна.




График 4. Хохирогчдын насны ангилал /2020-2024 он/



МОНГОЛЫН
Дотоод Ажлын
Төрийн Газар




МОНГОЛЫН ХҮҮЛЬ САХИУЛАХ УРЛАГ

Гэмт хэрэг үйлдсэн газар, цаг,

байдал

Сүүлийн 5 жилийн байдлаас харахад цахим хэрэгсэл ашиглан үйлдсэн залилах гэмт хэргийн 74.7 хувь нь ажлын өдрүүдэд, ихэвчлэн ажлын цагаар үйлдэгджээ.



Залилах гэмт хэргийн үйлдэгдсэн газар нь ихэвчлэн цахим орчинд үйлдэгдэж, хэрэг гарсан газар тодорхойгүй байдаг тул хохирогчийн хаяг, байршлаар мэдээллийн санд бүртгэгдэж байгаа тул гэмт хэрэг үйлдэгдсэн газар нь төдийлөн бодит статистик үзүүлэлт биш юм.




График 5. Гэмт хэрэг үйлдэгдсэн гараг, цаг 2020-2024 он

Цахим хэрэгсэл ашиглаж үйлдсэн залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зам

Интернэт, компьютер болон ухаалаг тоног төхөөрөмжүүд өндөр түвшинд хөгжиж байгаа нь сайшаалтай боловч энэ хөгжлийн хамт цахим хэрэгсэл ашиглан үйлдэгдэх гэмт хэрэг, цахим халдлагын тоо өсөж, их хэмжээний хохирол учруулсаар байна. Жишээ нь: Зарим эд хөрөнгийг устгах, нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжтэй байдал, тасралтгүй ажиллагаа, сэргээгдэх шинж, бодит байдал, найдвартай шинжийг алдагдуулах хор уршиг мөн цахим орчноор дамжуулан насанд хүрээгүй хүүхэд эсвэл хөгшин хүмүүсийг хууран мэхлэх, бага насны хүүхдүүдэд садар самуун сурталчлах, дарамтлах зэрэг гэмт хэргүүд нэмэгдэх болсон.

Судлаачид болон мэргэжилтнүүдийн зүгээс цахим орчны аюулгүй байдлыг хангах, хамгаалах арга хэмжээг авах, гэмт хэрэгтэй тэмцэх бодлого, эрх зүйн орчныг сайжруулах хэрэгцээ шаардлагатай бий болж байна.

Ингэснээр, технологи хөгжихийн хэрээр түүнийг даган гарах эрсдэлийг даван туулах, иргэдийн аюулгүй байдлыг хангах боломжийг бүрдүүлэхэд чухал нөлөөтэй юм. Иймд судлаачийн зүгээс авч болох зарим арга замуудыг дурдлаа. Үүнд:

1. Олон улсын хэмжээнд цахим аюулгүй байдлыг сурталчлан таниулах чиглэлээр зохион байгуулсан “Stop.Think.Connect.”, “EU Cybersecurity Strategy” зэрэг сургалт, кампанит ажлуудыг зохион байгуулах, дэмжих замаар иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлэх.

2. Цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад хэрэглэгчдийн аюулгүй байдлыг хангах хоёр давхар хамгаалалтын системийг /биометрийн хамгаалалт болон 2FA гэх мэт/ байгууллагын платформд интеграцчилах нэгдсэн зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

3. Кибер аюулыг судлах, тэмцэх шинэ технологиудыг хөгжүүлэх төв байгуулах, энэ чиглэлээр олон талын өдөрлөг, арга хэмжээг тогтмол зохион байгуулах зэрэг.



Эдгээр арга хэмжээ нь цахим хэрэгсэл ашиглан залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хамгаалахад чухал нөлөө үзүүлэхээс гадна, технологийн шинэчлэлт, сургалт, хууль зүйн ажиллагааг нэгтгэснээр хувь хүн, байгууллага, нийгмийн аюулгүй байдлыг нэмэгдүүлэх боломжтой гэж үзэж байна.

Дүгнэлт

Монгол Улсын хувьд цагийн хөгжил, технологийн хувьсгал, цахим шилжилт тогтмол өрнөж байгаа өнөө үед цахим орчны аюулгүй байдал, эрх зүйн зохицуулалт, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх шаардлага байсаар байна. Төр, хувийн хэвшлийн байгууллага, иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах, цахим орчинд бүрдэж буй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн хор уршгийг бууруулах чиглэлээр авах арга хэмжээ, бодлого боловсруулах шаардлагатай байна. Үүний тулд эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, эдгээр байгууллагуудын хамтын ажиллагааг идэвхжүүлэх, цахим технологийг нэвтрүүлэх, хүн хүч, технологийн чадавхыг бэхжүүлэх шаардлага үүсээд байна.

Мөн судалгааны үр дүнгээс харахад цахим хэрэгслүүдийг ашиглан үйлдэж буй залилах гэмт хэрэг, цахим орчинд явагдах гэмт хэрэг нэмэгдсээр байгаа талаар анхаарал хандуулах шаардлагатай. Түүнчлэн, цахим орчинд тавих хяналт шаардлага хангах түвшинд хүрээгүй, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд хандах хагас хяналттай байдлаас үүдэн гэмт хэрэг зөрчил нэмэгдэж байна. Ийнхүү гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хохирлыг бууруулахад цахим орчинд илэрч буй эрсдэл, аюулыг багасгах бодлого, арга хэмжээг заавал боловсронгуй болговол зохистой юм.

Тэр дундаа, Facebook, Телеграм зэрэг олон нийтийн сүлжээ, цахим платформууд нь терроризм, хүний амь нас хохирох нөхцөл байдал бий болсон, хүүхдийн садар самуун, секс сүрдүүлэг, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг /хар тамхи, хүн худалдаалах, мөнгө угаах/-т оролцох эрсдэл ихэссээр байгаагийн зэрэгцээ, эдгээр платформууд

тухайн хэрэг, зөрчил шалгахад хангалттай мэдээлэл өгч чадахгүй байгаатай холбогдуулан энэ төрлийн гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэхэд хүндрэл үүссээр байна.

Иймд цаашид Монгол Улсын цахим аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэхэд төрийн бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох, олон улсын туршлага, цахим технологийг өргөнөөр нэвтрүүлэх, хамтын ажиллагааг амжилттай хөгжүүлэх тал дээр онцгой анхаарч, бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх нь маш чухал болохыг дүгнэж байна.

Санал

1. Дэлхийн ихэнх улс орон Эрүүгийн хуульдаа цахим гэмт хэргийн талаар цогц суурь хууль баталж өгсөн байдаг. Иймд Монгол Улсын Эрүүгийн хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дах хэсэгт заасан үйлдэл бүрийг тус бүрчлэн салган зүйлчлэх, цахим төхөөрөмжийг ашиглан үйлдсэн гэмт хэргийг тусгайлан зааж өгөх;

2. Залилах гэмт хэргийн хохирогчдын сэтгэл зүйн байдалд мэргэжлийн судалгааны байгууллага, сэтгэл зүйчидтэй хамтран нөлөөллийн хүчин зүйлийн судалгааг хийх, урьдчилан сэргийлэх ажилд үр дүнтэй санал, шийдлүүдийг бий болгох боломжийг бүрдүүлэх;

3. Мөрдөгчид банк санхүү, үүрэн телефоны газраас мэдээлэл, лавлагаа, зөвшөөрөл авахад цаг хугацаа алдах явдал түгээмэл байдаг. Үүнтэй холбоотойгоор, цахим гэмт хэрэгтэй тэмцэхэд техник технологийн шийдлүүдийг ашиглан иргэд, байгууллагуудын мэдээлэл солилцох ажиллагааг сайжруулах;

Эдгээр санал, шийдлүүд нь цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн аюулгүй байдлыг хангах, хууль зүйн тогтолцоог сайжруулахад тодорхой хэмжээгээр хувь нэмэр оруулах боломжтой гэж үзэж байна.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт

1.declaration, D. (2024). *Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүл мэнд, Хар тамхитай тэмцэх алба*. Retrieved from www.unodc.org: www.unodc.org/documents/congress/Declaration



МОНГОЛ УЛСЫН
ХҮҮЛЬ САХИУЛАХ
УНДГАЙН СУРГУУЛЬ

2.Sieber, U. (1991). The International Emergence of Criminal Information Law. *The International Emergence of Criminal Information Law*, (p. 56).

3.Sieber, U. (1994). Information Technology Crime – National Legislation's and International Initiatives. *Information Technology Crime – National Legislation's and International Initiatives*, (p. 49).

4.Г.Даштүдэв. (2007). *Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зүй*. Улаанбаатар: Адмон ХХК.

5.Г.Думбарай. (1987). *Гэмт хэрэг, эрх зүйн зөрчилтэй тэмцэх үндсэн чиглэл нь*

урьдчилан сэргийлэх явдал мөн. Улаанбаатар: Битпресс.

6.Хороо, в. З. (1989 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр). *Компьютертэй холбоотой гэмт хэрэг: Зөвлөмж № R(89) 9* . Гэмт хэргийн асуудал эрхэлсэн Европын Хороо.

7.Хороо, Е. з. (1989.09.13). *Компьютертэй холбоотой гэмт хэрэг: Зөвлөмж №R(89) 9*. Гэмт хэргийн асуудал эрхэлсэн Европын Хороо.

8.Хууль, Э. (2015, 12 3). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. Retrieved from legalinfo.mn:

<https://legalinfo.mn/mn/detail/11634>